



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 13/01

Сайншанд сум

Зорилтот хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, 20.3, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.6, 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.15, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих аймгийн зорилтот хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулан хэрэгжилтийн тайланг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооны ахлагч (У.Энхмаа), аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Б.ГАНЗОРИГ

442230084



“АНАГААХЫН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АЙМГИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР”

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын Хөдөөгийн сэргэлт, Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн хүрээнд төвлөрлийг сааруулах, орон нутаг дахь их, дээд сургуулийн үйл ажиллагааг дэмжих, багшлах хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэргэшсэн, чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилт арга хэмжээг үндэслэн “Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих аймгийн зорилтот хөтөлбөр”-ийн төслийг боловсруулав.

1.2.ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА:

АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль нь зүүн болон говийн бүсийн төдийгүй, бусад аймаг, хот, нийслэлийн эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргадаг, Монгол улсын орон нутаг дахь ууган сургуулиудын нэг билээ.

Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын одоогийн барилга байгууламжууд нь насжилт өндөр буюу хичээлийн 1-р байр 1967 онд Дорноговь аймгийн Барилга угсралтын конторын барьсан хамгийн анхны барилга, соёлын танхим 1972 онд, оюутны байр 1987 онд, хичээлийн 2-р байр 1989 онд хүүхдийн эмнэлгийн зориулалтаар баригдсан, барилгын чанар муудсан учраас орон нутагт суралцах оюутан залуусын сурах таатай орчныг бүрдүүлэх, ажиллаж буй багш, ажилтны ажиллах нөхцөлийг сайжруулан стандартын шаардлага бүхий барилга байгууламжтай болгох
- Дорноговь аймгийн хөгжил, бүтээн байгуулалт, уул уурхай, үйлдвэржилт нэмэгдэж байгаатай уялдан хүн амын тоо өсөхийн хирээр эрүүл мэндийн байгууллагад ажиллах хүний нөөцийг бэлтгэх хэрэгцээ шаардлага зайлшгүй бий болно.
- Тус сургуульд суралцаж төгсөж буй оюутнууд нь дотуур байрны хүрэлцээ муутайн улмаас Сайншанд суманд орон сууц түрээслэн амьдрах, худалдан авалт хийх зэргээр орон нутгийн айл өрх, бизнес эрхлэгчийн орлогыг нэмэгдүүлдэг төдийгүй хүн ам зүйн бодлогод нөлөөлөн гэр бүл болж үлдэх, орон нутагт тогтвортой суурьшиж амьдарч, ажилладаг

- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх сургалтад орчин үеийн эмчилгээ оношилгооны багаж, тоног төхөөрөмжийг ашиглах, зааж сургах, мэдлэг, ур чадвар, хандлагатай оюутнуудыг төгсгөн гаргах
- Анагаахын боловсрол олгох тэргүүлэх багш, боловсон хүчнийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нийгмийн баталгааг хангахад салбарын болон орон нутгийн дэмжлэгийг үзүүлэх
- Орон нутагт нэн шаардлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх, анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх,



1.3. АШУУИС-ИЙН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР АНАГААХ УХААНЫ СУРГУУЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Тус сургууль нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1962 оны 04-р сарын 18-ны өдрийн 200-р тогтоолоор *Анагаах Ухааны Дунд сургууль* нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1991 оны Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 124/A44 тоот тушаалаар *АУИС-ийн харьяа Анагаах Ухааны Коллеж*, 1996 оны Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Дорноговь аймгийн Засаг даргын хамтарсан А/88, 150/90 тоот тушаалаар аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй нийлүүлэн, *АУИС-ийн харьяа Анагаах Ухааны Эрдэм Шинжилгээний Сургалтын төв*, 1997 оны Гэгээрлийн яам, ЭМНХЯ-тай хамтарсан А/176, 120 тоот тушаалаар Нэгдсэн эмнэлгээс тусгаарлан, *АУИС-ийн харьяа Анагаах Ухааны Коллеж*, 2004 оны БСШУСайдын 238 тоот тушаалаар *ЭМШУИС-ийн харьяа Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны Коллеж*, 2010 оны БСШУЯСайдын №36 тоот тушаалаар *ЭМШУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургууль*, 2014 онд Боловсрол, шинжлэх ухааны Сайдын А/134 тушаал, ЭМШУИС-ийн удирдах зөвлөлийн 05-р тогтоолоор *АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль* болон өргөжсөн.

Дорноговь аймаг дахь салбар анагаах ухааны сургууль нь хүний их эмч бакалавр 6 жил, Сувилагч бакалавр 4 жил, Сувилагч, Эм найруулагч, Лабораторийн техникч, Эх баригч, Уламжлалтын сувилагч дипломын зэрэгтэй 3 жилээр тус тус бэлтгэж, сургалтын үйл ажиллагаа явуулдаг, 61 жилийн түүх хугацаанд 8000 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэн гаргасан бөгөөд говийн болон зүүн бүсийн аймгуудын эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 85-90 хувийг бүрдүүлж байна.

Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний зөвлөлөөр 2000, 2005, 2018 онуудад магадлан итгэмжлэгдсэн, чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартыг 2018 оноос нэвтрүүлж, 2022 онд Сувилахуйн дипломын хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн.

2023-2024 оны хичээлийн жилд 560 гаруй оюутантай, 70 гаруй багш, ажилчинтай. Нийт 34 үндсэн багш ажиллаж байгаагаас 12,5 % доктор, 98 % магистр, 4,7% дэд профессор, 16,6 % клиникийн профессор, 9,5 % зөвлөх зэрэгтэй, 30,9 % нь мэргэжлийн ахлах, тэргүүлэх зэрэгтэй байна.

Тус сургуулийн элсэлт, төгсөлт, төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл сүүлийн 3 жил элсэгчдийн тоо нэмэгдсэн, ажил эрхлэлтийн хувь дундажаар 81,6 хувьтай байна.

Сүүлийн 5 жилийн элсэлт, төгсөлт, ажил эрхлэлтийн үзүүлэлт

Хүснэгт 1

№	Он	2023	2022	2021	2020	2019	Дундаж
1	Элсэлт	170	140	135	243	91	156
2	Төгсөлт	166	110	122	105	138	128

3	Ажил эрхлэлт	80%	82%	76%	90%	80%	81.6%
---	--------------	-----	-----	-----	-----	-----	-------

АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн 2018-2023 оны хичээлийн жилийн төгсөгчдийн сурлагын амжилт, чанар 98,5 хувь байгаа нь онолын мэдлэг, гардан ур чадварыг хослуулан эзэмшүүлж чадаж байгааг илтгэж байна.

Шалгалтын хэлбэр	2018-2019 он		2019-2020 он		2020-2021 он		2021-2022 он		2022-2023 он		Дундаж хувь
	Амжилт	Чанар	Амжилт	Чанар	Амжилт	Чанар	Амжилт	Чанар	Амжилт	Чанар	
Мэдлэгийн үнэлгээний хувь	92.8	65.6	99.5	93.7	100	100	100	100	100	100	98.5%
Ур чадварын үнэлгээний хувь	95.8	89.3	97.5	78.7	100	100	100	94.2	100	91.1	98.7%

Эмнэл зүйн сургалтын орчныг бүрдүүлэх, багш, оюутнуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор 2015 оноос орон нутгийн дэмжлэгтэйгээр “Мандах наран-Оюутан түшиц эмнэлэг”-ийн байртай болж 12 нэр төрлийн нарийн мэргэжлийн кабинет бүхий үүдэн эмнэлгийн тусгай зөвшөөрөлтэйгөөр ажиллуулж байна. Энэ нь их сургуулийн эмнэлгийн хөгжлийг бий болгох, аймгийн эрүүл мэндийн салбарын үзлэг, оношилгооны ачааллыг хуваалцах, эмнэл зүйн сургалтын суурь болж өгч байгаагаараа давуу талтай юм. Эмч, сувилагч багш нар сургалтын цагаас гадна тус эмнэлэгт ажилладаг.

Эмнэл зүйн дадлага ур чадварыг олгоход аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг бааз эмнэлэг болгон хамтран ажилладаг бөгөөд нарийн мэргэжлийн эмч, сувилагч нар гэрээт багшаар хичээл заадаг. Аймаг орон нутагт онцгой байдлын үед болон, өвчлөл нэмэгдэж, эмнэлгийн ачаалал ихэссэн тохиолдолд тус сургуулийн эмч, сувилагч багш, оюутнууд дайчлагдан ажилладаг.

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль нь сүүлийн 5 жилийн дундаж нийт орлого 1,536.42 /сая төгрөг/ үүнээс сургалтын төлбөрийн дундаж орлого 1,245.0 /сая төгрөг/ бөгөөд нийт орлогын 81 хувийг эзэлдэг.

Багш, ажилтан албан хаагчдын цалингийн сүлжээ, шатлал нь АШУҮИС-ийн ТУЗ-аар батлагддаг. 2020 онд 10 хувиар, 2021 онд 10 хувиар, 2022 онд 10 хувиар, 2023 онд 25 хувиар цалинг шат дараалан нэмэгдүүлж, 5 жилийн байдлаар нийт 25 хувиар үндсэн цалинг нэмэгдүүлсэн боловч, бусад салбартай харьцуулахад харьцангуй бага түвшинд байсаар байна.

Цалингийн мэдээлэл төгрөгөөр

Он	Багш /магистр/	Багш /доктор, профессор/	Үйлчилгээ /Мэргэжилтэн/	Үйлчилгээний бусад
2018	763,901	862,923	659,540	469,821
2020	840,291	949,215	725,494	516,803
2021	924,320	1,044,137	798,043	568,483
2022	1,016,752	1,148,551	877,847	625,331
2023	1,270,940	1,435,689	1,097,309	781,664

Сүүлийн 5 жилийн байдлаар тус сургуулийн хичээлийн байр, оюутны байранд их засварууд дараах байдлаар хийгдсэн.

Үүнд:

- 2018 онд: Хичээлийн 2-р байрны засвар 79.7 сая төгрөг /өөрийн хөрөнгөөр/
- 2019 онд: Оюутны дотуур байрны 1-р давхрын засвар 49.8 сая төгрөг /өөрийн хөрөнгөөр/
- 2020 онд Оюутны дотуур байрны 2, 3-р давхрын засвар, гадна фасад 232.3 сая төгрөг /Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар/
- 2021 онд: Хичээлийн 1-р байрны коридорын засвар 88.2 сая төгрөг /өөрийн хөрөнгөөр/

Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, багш нарыг чадавхжуулах, багш, оюутан солилцоо, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр 1995 оноос хойш 6 орны 14 сургуулиудтай хамтран ажилладаг.

Дорноговь аймагт төрийн эрүүл мэндийн салбарт нийт 1087 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаагийн 90 гаруй хувийг тус сургуулийн төгсөгчид эзэлж байна.

2022 оныг 2018 онтой харьцуулахад их эмч 28, эм зүйч 18, сувилагч 10, эмнэлгийн бусад ажилчид 36 хүнээр нэмэгдэж, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд 18 хүнээр буурсан байна.

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт 82.9% байгаа нь орон нутагт боловсон хүчин бэлтгэдэг сургуультай аймгийн хувьд хангалтгүй, сумын эрүүл мэндийн төвүүдэд эмч сувилагчийн хүрэлцээ дутмаг, аль ч шатны эрүүл мэндийн байгууллагын ажлын ачаалал их байгаа нь хүний нөөцийн дутагдалтай байгааг илэрхийлж байна.

Монгол Улсын Засгийн газраас баримтлан хэрэгжүүлж буй бодлого, орон нутгийн хөгжлийн чиг хандлагыг дагаад хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж, орон нутгийн төдийгүй эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан ажиллах хүний нөөцийг бодлогоор бэлтгэх, сургах, сургалтын орчин, багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийх, багшлах боловсон хүчнийг чадавхжуулах зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байна.

1.4.SWOT-TOWS МАТРИЦ ШИНЖИЛГЭЭ

SWOT, TOWS МАТРИЦ	Давуу тал S	Сул тал W
Дотоод хүчин зүйл	- Олон улсад болон МУ-ын хэмжээнд эрэлт хэрэгцээтэй 6 мэргэжлээр салбарын хүний нөөцийн бэлтгэдэг - 1962 оноос зүүн болон говийн бүс нутагт эмч эмнэлгийн мэргэжилтэн бэлдсэн туршлагатай. - Зүүн болон говийн бүсийн ЭМБ – д ажиллаж байгаа эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтний 85-90 % нь тус сургуулийн төгсөгчид - Сургалтын орчин, материаллаг бааз бүрдсэн - Сургалт, судалгаа, эрүүл мэндийн үнэлгээг гүйцэтгэх чадвар бүхий тогтвор суурьшилтай багшлах боловсон хүчинтэй - Сувилахуйн мэргэжлээр суралцах оюутны зардлыг /2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн МУ-	-Сургалтын орчин, нөхцөл, барилгын чанар муудсан, бүрэн хангагдаагүй, -Сургалтын тоног төхөөрөмжийн хангалт, хүрэлцээ дутмаг -Сургалт, эмнэл зүйн чиглэлээр томоохон эрдэм шинжилгээ судалгаа хомс, ОУ-ын хэмжээнд хэвлэгдсэн бүтээл цөөн
Гадаад хүчин зүйл		

	ын Засгийн газрын тогтоол дугаар 70/, бакалавраар суралцах оюутны сургалтын төлбөрийн 50 хувийг /МУ-ын ЗГ-ийн 321-р тогтоол/ төр хариуцах болсон - Эрэлт хэрэгцээтэй мэргэжил нэг учраас орон нутгийн байгууллагуудын тэтгэлэгт хамрагдах боломжтой.	
Боломж О	SO	WO
- Сургалтын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлүүлж эхэлсэн - Ажил олгогч нартай уулзаж, санал бодлоо солилцдог - Суралцагсад ажиллангаа шаталсан сургалтад хамрагдах боломжтой - Орон нутгийн захиалгаар суралцуулах боломжтой - ЭЕШ-ыг 2 удаа авах болсон	- Зүүн болон говийн бүсэд байгаа анагаахын ганц сургууль тул бүс нутгаас болон бусад аймаг хотуудаас элсэн суралцах оюутны тоог нэмэгдүүлэх - Цахим сургалт хөгжсөнтэй холбоотой ажлын байран дахь сургалтыг зохион байгуулах	- Ажил олгогчийн оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах - Сургалт, орчин нөхцөлийн чиглэлээр оролцогч талуудаас судалгаа тогтмол авч, үр дүнг тооцон хэрэгжүүлэх - Сургалтын хөтөлбөрт нэмэлт шинэчлэлтүүдийг хийж ажил олгогчийн хүссэн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх
Аюул, эрсдэл Т	ST	WT
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал ихтэй учраас элсэгчид цөөрөх магадлалтай - Мэргэжил, сэтгэл зүй болон санхүүгийн дэмжлэг сулаас бусад салбар, сургуульд шилжиж боловсон хүчний тогтвор суурьшил алдагдах - Хөдөөгөөс хот руу шилжин суурьших хөдөлгөөн нэмэгдэх	- Оролцогч талуудын судалгаанд үндэслэн сургалтын арга, барил, суралцах орчин, нөхцөлийг өөрчлөн сургалтын чанарыг сайжруулах	- Элсэлт, суралцагчдын тоо цөөрөх - Багшлах боловсон хүчнээ алдах

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Орон нутагт их сургуулийн цогцолборыг жишиг байдлаар хөгжүүлж, шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэндийн салбарт манлайлагч их сургууль болгоход дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Хөтөлбөрийн зорилгыг дараах 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

1. **ЧАНАРТАЙ СУРГАЛТЫН ОРЧИН:** Анагаахын сургуулийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулахтай уялдуулан хичээлийн байр, оюутны дотуур байр, соёлын төв, их сургуулийн эмнэлэг, багш ажилчдын орон сууцыг барих, лаборатори, эмнэл зүйн сургалтын орчин үеийн болон хиймэл оюун ухаанд суурилсан тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх;
2. **ЧАНАРТАЙ ТҮНШЛЭЛ:** Салбарын хүний нөөцийн бодлого, орон нутгийн хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээтэй нийцүүлэн хүний нөөцийг төлөвлөх, орон

нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай нягт харилцаатай ажиллах, нэн шаардлагатай мэргэжлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх;

3. **ЧАНАРТАЙ БАГШ:** Анагаахын сургуулийн багшлах боловсон хүчнийг чадавхжуулах, анагаахын боловсрол олгох сургалтын чанарыг сайжруулах, эрдмийн зэрэг цол авахад дэмжлэг үзүүлэх, нарийн мэргэжилд сургах, ажиллах, амьдрах нийгмийн баталгааг хангах;
4. **ЧАНАРТАЙ ЭМНЭЛЭГ:** Их сургуулийн эмнэлгийг хөгжлийн жишигт хүрэхүйц эмнэл зүйн орчин бүрдүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн салбарын ачааллыг хуваалцаж, орон нутгийн хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан, орчин үеийн стандартад нийцсэн оношилгоо эмчилгээг нэвтрүүлэх;
5. **ЧАНАРТАЙ ХАРИЛЦАА:** Сургуулийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын түвшинд сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хамтран зохион байгуулах, багш, оюутан солилцооны хөтөлбөрийг өргөжүүлэх.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХУГАЦАА, ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих аймгийн зорилтот хөтөлбөр нь 2024-2027 онуудад нийт 4 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд хөтөлбөрийн үндсэн хэрэгжүүлэгч нь АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС, хамтран хэрэгжүүлэгч нь АЗДТГ, БШУГ, ЭМГ бусад холбогдох байгууллагууд байна.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

5.1.Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

5.1.1.ЧАНАРТАЙ СУРГАЛТЫН ОРЧИН: Анагаахын сургуулийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулахтай уялдуулан хичээлийн байр, оюутны дотуур байрыг шинэчлэх, лаборатори, эмнэл зүйн сургалтад орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангалтыг нэмэгдүүлэх:

5.1.1.1. Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын хичээлийн байрыг 400 оюутны багтаамжтайгаар шинэчлэн барих;

5.1.1.2. Оюутны ая тухтай амьдрах орчныг сайжруулах, 250 оюутны дотуур байрыг барих;

5.1.1.3. Оюутнуудын суралцах орчин, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг тасралтгүй явуулах Соёлын төвийг шинээр барих;

5.1.1.4. Сургалтын орчин нөхцөлийг стандартын дагуу бий болгох;

5.1.1.5. Сургалтын лабораторийн ажиллах орчныг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.

5.2.Хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

5.2.1. ЧАНАРТАЙ ТҮНШЛЭЛ: Салбарын хүний нөөцийн бодлоготой уялдуулсан орон нутгийн хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээтэй нийцүүлэн хүний нөөцийг төлөвлөх, нэн шаардлагатай мэргэжлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, орон нутгийг эмнэлгийн мэргэжилтнээр хангах, мэдлэг чадварыг дээшлүүлэх:

5.2.1.1. Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг мэргэжил тус бүрээр бүтэц стандартын дагуу хангах, тоог нэмэгдүүлэх, орон нутгийн удирдлагын дэмжлэгийг сайжруулах;

- 5.2.1.2. Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, сум бүрийг Эх баригчаар хангах, оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх;
- 5.2.1.3. Эрүүл мэндийн салбар байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийг гэрээт багш, эмчээр ажиллуулах, цалин хөлс, урамшууллыг шийдвэрлэх;
- 5.2.1.4. Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг хамтран зохион байгуулах;
- 5.2.1.5. АШУУИС-ийн салбар сургуулийн эмч, сувилагч багш нарыг мэргэжлийн сургалтуудад тогтмол оролцуулах;
- 5.2.1.6. Багш-Эмч, Эмч-Багш тогтолцоог бэхжүүлж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх.

- 82.1.2

5.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

5.3.1. ЧАНАРТАЙ БАГШ: Анагаахын боловсрол олгох сургалтын чанарыг сайжруулах, багшлах боловсон хүчнийг чадавхжуулах, эрдмийн зэрэг цол, нарийн мэргэжилд сургах, ажиллах, амьдрах нийгмийн баталгааг хангах:

- 5.3.1.1. Анагаахын боловсрол олгох сургалтын чанарыг сайжруулан, магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх;
- 5.3.1.2. Элсэлтийн маркетингийн баг ажиллуулах, мэдээллийг хүргэх, шинээр элсэгчдийн тоог нэмэгдүүлэх;
- 5.3.1.3. Анагаахын боловсрол олгох багш нарыг эрдэмжүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжих, Докторын зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх;
- 5.3.1.4. Багшлах боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор багш, ажилчдын орон сууцны асуудлыг боломжит хувилбараар шийдвэрлэх;
- 5.3.1.5. Эмнэл зүйн дадлага туршлагатай эмч нарыг багшаар ажиллуулж эмнэлэг сургууль хоорондын уялдааг сайжруулах
- 5.3.1.6. АШУУИС-ийн салбар сургуульд ажиллаж буй багш ажилчдын нийгмийн баталгааг хангах, цалин урамшууллыг нэмэгдүүлэх;
- 5.3.1.7. Төгсөгчдийн сурлагын амжилт, чанарыг ахиулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, орон нутагт ажлын байраар хангах.

5.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

5.4.1. ЧАНАРТАЙ ЭМНЭЛЭГ: Их сургуулийн эмнэлгийг хөгжлийн жишигт хүрэхүйц эмнэл зүйн орчин бүрдүүлэх, орчин үеийн оношилгоо эмчилгээг нэвтрүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн салбарын зарим ачааллыг хуваалцах, хамтран ажиллах:

- 5.4.1.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, орчин үеийн оношилгоо эмчилгээг нэвтрүүлэх;
- 5.4.1.2. Орчин үеийн хиймэл оюун ухаанд суурилсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх;
- 5.4.1.3. Эмнэл зүйн лабораторийн ажиллах орчныг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ;
- 5.4.1.4. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, нарийн мэргэжлийн эмч нарыг урьж ажиллуулах.

5.5.Хөтөлбөрийн 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

5.5.1.ЧАНАРТАЙ ХАРИЛЦАА:Салбар сургуулийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын түвшинд сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хамтран хийх, багш, оюутан солилцох:

- 5.5.1.1. Сургуулийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, бусад орнуудын анагаах, сувилахуйн сургуулиудтай хамтран ажиллах;
 - 5.5.1.2. Хамтын ажиллагаатай сургуулиудад багш оюутан солилцоогоор сургах, туршлага судлах;
 - 5.5.1.3. Гадаад харилцааг өргөтгөх зорилгоор англи хэл, япон хэлний сургалтын чанарыг сайжруулах, клуб, төвүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;
 - 5.5.1.4. Гадаадын чансаа өндөртэй сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлэх, бусад орны судлаач нартай хамтран ажиллах;
 - 5.5.1.5. Сургалтад олон улсын сургалтын арга технологийг нэвтрүүлэх
- 5.6.** Зорилтот хөтөлбөрийг бусад аймаг орон нутагтай хамтран хэрэгжүүлэх боломжийг судалж бүс нутгийн хамтын ажиллагааны түншлэлийн хүрээнд зохион байгуулах

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

Үүнд:

- АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн төсөв;
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;
- Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн дэмжлэг;
- Хандив тусламж;
- Бусад хөрөнгийн эх үүсвэр зэрэг болно.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

- Сургалтын барилга байгууламж нэмэгдэж, хичээлийн байр, оюутны дотуур байр, соёлын төв, багш ажилчдын орон сууц баригдсан байна.
- Суралцах оюутны тоо 1000 хүрч, оюутны сурах, амьдрах таатай орчин бүрдэнэ.
- Сургалтын болон эмнэл зүйн багаж, тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдэнэ.
- Эрдмийн зэрэг, цолтой багшлах боловсон хүчин нэмэгдэж, докторын зэрэгтэй багш 30-аас дээш хувьд хүрсэн байна.
- Чанартай боловсон хүчнийг бэлтгэн гаргаснаар Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт 95 хувьд хүрнэ.
- Орон нутагт их сургуулийн цогцолборыг жишиг байдлаар хөгжүүлж, манлайлагч их сургууль болно.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Анагаахын боловсрол олгох сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих аймгийн зорилтот хөтөлбөр”-ийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гаргах ба төлөвлөгөөний хэрэгжилт, хөтөлбөрийн үр дүнд АШУУИС-ийн Дорноговь

аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн ЗХНА-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ. Гүйцэтгэлийн Хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар жил бүр төлөвлөгөөний хэрэгжилт, нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан хийж гүйцэтгэнэ.

Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх ба хөтөлбөрийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2023/	Зорилтот түвшин			
			2024 он	2025 он	2026 он	2027 он
1	Суралцаж буй оюутны тоо	540	650	750	850	1000
2	Шинээр элсэгчдийн тоо	180	250	280	300	300
3	Бэлтгэж буй мэргэжлийн тоо	6	7	8	9	10
5	Багшлах боловсон хүчний тоо	34	40	50	55	60
6	Анги кабинетын тоо	42	45	60	60	60
7	Лекцийн танхимын тоо	5	6	10	10	10
8	Лабораторийн тоо	3	4	6	6	6
9	Докторын зэрэгтэй багшийн хувь	12.5%	15%	18%	20%	30%
10	Мэргэжлийн зэрэг цолтой багшийн эзлэх хувь	30.6%	35%	38%	40%	45%
11	Эрдэм шинжилгээний өгүүллийн тоо	2	5	6	8	10
12	Эрдэм шинжилгээний илтгэлийн тоо	25	30	35	40	45
13	Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	1	2	3	4	5
14	Сургалтын багаж, Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	60%	70%	80%	90%	100%
15	Номын сангийн фондын нийт номын тоо	17212	17500	18000	18200	18500
16	Цахим номын ашиглалтын хувь	48%	65%	75%	85%	100%
17	Цахим хандалтын тоо	4250	4500	5000	5500	6000
18	Оюутны байранд амьдардаг оюутны тоо	220	250	300	400	500
19	Ногоон байгууламжийн талбайн хэмжээ	250м2	280м2	300м2	320м2	350м2
20	Төгсөлтийн дараах сургалтын чиглэлийн тоо	5	7	8	9	10
21	Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь	81.6%	85%	88%	90%	95%
22	Шинээр бэлтгэж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо	16	16	16	16	20